



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2019 оны 09 сарын 02 өдөр

Дугаар A-229

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22.4 дэх хэсэг, Хамтын ажиллагааны зөвлөлийн 2019 оны 06 сарын 28-ны хурлын зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Санхүүгийн мэдээллийн албаны дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөлийн ажиллах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн А-115 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд Ерөнхийлөгч (О.Эрдэмбилэг)-д даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТАЙХАН

Монголбанкны Ерөнхийлөгчийн
2019 оны 09 дүгээр сарын 02-ны одрийн
A-229 дугаар тушаалын хавсралт

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн 22 дугаар зүйлд заасан Хамтын ажиллагааны зөвлөл (цаашид “ХАЗ” гэх)-ийн үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2.ХАЗ нь үйл ажиллагаагаа “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмын хүрээнд явуулна.

1.3.ХАЗ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, эрсдэлийг бууруулах урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл хэлбэрээр ажиллана.

Хоёр. Хамтын ажиллагааны зовтолийн удирдлага, бүрэлдэхүүн, зохион байгуулалт

2.1.ХАЗ-ийн бүрэлдэхүүнийг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт заасан байгууллагын даргын саналаар, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт зааснаас бусад байгууллагын хувьд холбогдох байгууллагын даргатай зөвшилцсөнөөр Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална. ХАЗ-ийн бүрэлдэхүүнд тухайн байгууллагыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан нь газар, эсхүл бие даасан хэлтсийн удирдлага, түүнээс дээш зэрэглэл, шатлалын албан тушаалтан байна.

2.2.ХАЗ-ийг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт заасан байгууллага 1 жилийн хугацаагаар ээлжлэн удирдана.

2.3.ХАЗ-ийг удирдах саналыг гишүүн байгууллагаас жил бүрийн 12 дугаар сард албан бичгээр авч, зөвлөлийн гишүүдийн олонхын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална. ХАЗ-ийг удирдах санал гаргасан бол Монголбанкны төлөөлөл ХАЗ-ийг удирдана.

2.4.ХАЗ-ийн орлогч даргын үүргийг Санхүүгийн мэдээллийн албаны дарга гүйцэтгэнэ. ХАЗ-ийн нарийн бичгээр СМА-аас томилогдсон ажилтан ажиллана.

2.5.ХАЗ-ийн дэргэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор хамтран ажиллах чиг үүрэгтэй хууль сахиулах, хяналт шалгалт, хууль эрх зүй, судалгаа дүн шинжилгээний болон бусад асуудал хариуцсан Ажлын хэсэг ажиллаж болно.

2.6.ХАЗ-ийн хурлаар ажлын хэсгийг байгуулах, ахлагч, гишүүдийг томилохдоо оролцогч байгууллагаас санал авч, баталгаажуулах бөгөөд ажлын хэсэгт ХАЗ-ийн гишүүдээс гадна бусад төрийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас төлөөлөл оруулж болно.

2.7.ХАЗ-ийн дэргэдэх Ажлын хэсгийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь уулзалт байна. Шаардлагатай нөхцөлд уулзалтын үр дүнг ХАЗ-ийн хурлаар зөвлөмж гаргуулахаар хэлэлцүүлж болно.

2.8.Ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулах саналыг гишүүдийн олонхи гаргаснаар эсхүл Ажлын хэсгийн ахлагч гаргаснаар тухай бүр уулзалтыг /цаашид “ажлын хэсгийн уулзалт” гэх/ зохион байгуулна.

2.9.Ажлын хэсгийн уулзалтаар төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг танилцуулах тохиолдолд уулзалтыг санаачлагч тал Ажлын хэсгийн ахлагчтай хамтран тухайн уулзалтад оролцох бүрэлдэхүүнийг зарлаж, шаардлагатай бол нууцлалын баталгааг Төрийн болон албаны нууцын тухай хууль бусад холбогдох хууль, журмын дагуу гаргуулан авна.

2.10.ХАЗ-ийн дэргэдэх Ажлын хэсгийн уулзалтын товч тэмдэглэлийг СМА-ны төлөөлөл хөтөлж ХАЗ-ийн даргад танилцуулна.

Гурав. Хамтын ажиллагааны зөвлөлийн чиг үүрэг

3. ХАЗ нь дараах чиг үүрэгтэй:

3.1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох зөвлөмж, санал гаргах;

3.2 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаатай холбоотой Эрсдэлийг Монгол улсын хэмжээнд судлах, эрсдэлийн үнэлгээ хийх, үр дүнүү тооцох ажиллагааг хоёр жилд нэг удаа зохион байгуулах;

3.3.Энэ журмын 3.2-т заасан эрсдэлийн үнэлгээнд үндэслэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, үр дүнтэй, оновчтой зохион байгуулах талаар зөвлөмж гаргах;

3.4.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх нөхцөл байдал, үр дүнгийн талаар мэдээлэл солилцох;

3.5.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагын үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж буй эсэхтэй танилцаж мөрдүүлэх талаар санал, зөвлөмж гаргах;

3.6.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан дүрэм, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний болон ХАЗ-өөс гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих, гүйцэтгэлийн явцтай танилцах, шаардлагатай бол хэрэгжилтийг хангаж ажиллахыг шаардах, гүйцэтгэлийг ХАЗ-өөр хэлэлцүүлэх, хугацаатай үүрэг даалгавар өгөх, үйл ажиллагааны уялдаа холбоог хангуулах зэрэг холбогдох арга хэмжээг авах;

3.7.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг олон улсын стандарт, Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага /ФАТФ/-ын 40 зөвлөмжид нийцүүлэх талаар санал гарган танилцуулах;

3.8. Гишүүн байгууллагын үйл ажиллагааг үндэсний болон бүс нутаг, олон улсын байгууллагын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажилтай уялдуулахад дэмжлэг үзүүлэх;

3.9. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллага, хувийн хэвшил болон олон нийтэд зориулсан сургалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;

3.10. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх өргөдөл, гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх;

3.11. Санхүүгийн мэдээллийн албаны бүтэц, зохион байгуулалт, төсөв, үйл ажиллагааны зардлын талаар санал гаргах, танилцуулах, шийдвэрлүүлэх;

3.12. ХАЗ-ийн дэргэдэх Ажлын хэсгийн хэрэгжүүлж байгаа арга хэмжээтэй танилцах, хэрэгжүүлэх санал зөвлөмж, хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохион байгуулах;

3.13. ХАЗ-ын гаргасан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих.

Дөрөв. ХАЗ-ийн хурал, зөвлөмж

4.1. ХАЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хурал /цаашид “зөвлөлийн хурал” гэх/ байна. Зөвлөлийн хуралыг зохион байгуулах ажиллагааг ХАЗ-ийн Ажлын алба буюу Санхүүгийн мэдээллийн алба хариуцан гүйцэтгэнэ.

4.2. ХАЗ-ийн Зөвлөлийн хурлыг ХАЗ-ийн дарга, түүний түр эзгүйд орлогч дарга удирдана.

4.3. Онц чухал асуудлаар зайлшгүй шаардлагатай тохиолдолд ХАЗ-ийг хуралдуулахгүйгээр эчнээ санал хураалт явуулж, саналыг албан ёсоор бичгээр авсны үндсэн дээр асуудлыг нэн яаралтай горимоор шийдвэрлэж болно.

4.4. ХАЗ нь улирал тутамд хуралдана. Ээлжит бус хурлыг зөвлөлийн даргын санаачилгаар зарлан хуралдуулж болно.

4.5. ХАЗ-ийн хурал нь зөвлөлийн гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөрт тооцогдоно.

4.6. ХАЗ-ийн хурлын тов (байршил, цаг), түүгээр хэлэлцэх асуудлын жагсаалтыг ХАЗ-ийн нарийн бичгийн дарга хурал эхлэхээс ажлын 3 /турав/ өдрийн өмнө албан бичгээр болон цахим шуудангаар хүргүүлсэн байна.

4.7. ХАЗ нь хурлаар хэлэлцэж буй аливаа асуудлыг хуралд оролцож буй гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх бөгөөд санал тэнцсэн тохиолдолд ХАЗ-ын даргын саналаар тухайн асуудлыг шийдвэрлэнэ.

4.8. ХАЗ-ийн хурлын үйл ажиллагааны явцад дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөх бөгөөд хэлэлцсэн асуудал бүрээр тухайлан гаргасан эцсийн шийдвэрийг тэмдэглэлд “ЗӨВЛӨСӨН нь:” гэсэн хэлбэрээр тусгана. ХАЗ-ийн хурлын тэмдэглэлд дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ХАЗ-ийн хурлын тэмдэглэлийг хэлэлцсэн асуудал бүрээр хураангуй хэлбэрээр гаргаж, баримт бичгийг холбогдох байгууллагад хүргүүлнэ.

4.9. ХАЗ-ийн зөвлөмжийн хэрэгжилт, түүний явц байдал, тайлбарыг ХАЗ-ийн Ажлын алба хагас, бүтэн жилээр нэгтгэж дүнг ХАЗ-ийн хуралд танилцуулна.

4.10.ХАЗ-ийн хурлын тэмдэглэлд хэлэлцсэн асуудал, түүнийг хэлэлцүүлэх явцад гишүүдийн хэлсэн үг, тавьсан санал, асуулт, хариулт зэргийг үнэн зөв, бүрэн гүйцэд тэмдэглэж тусгах бөгөөд нэгэнт тэмдэглэлд тусгаж баталгаажуулсан шийдвэрт дараа нь утга агуулгын өөрчлөлт оруулахыг хориглоно.

4.11.ХАЗ-ийн хурлын тэмдэглэл, хуулиар хэлэлцсэн асуудалтай холбогдох бичиг баримтыг Санхүүгийн мэдээллийн алба хадгалах бөгөөд ХАЗ-ийн гишүүдэд тэдгээрийг танилцуулж болно.

Тав. Хамтын ажиллагааны зөвлөлийн бүрэн эрх, үүрэг

5.1.ХАЗ нь дараах бүрэн эрхтэй:

5.1.1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны тайланг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулах;

5.1.2.Өөрийн эрхлэх хүрээний асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал, зөвлөмж өгөх, хэрэгжилтийг хангахыг шаардах, гүйцэтгэлийн тайлан, мэдээ, илтгэлийг ХАЗ-ийн хурлаар хэлэлцэх;

5.1.3.ХАЗ-ийн хурлаар тухайлан хэлэлцсэн асуудлаар холбогдох байгууллагын удирдлагатай ярилцах, санал солилцох;

5.1.4.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал гаргах;

5.1.5.ХАЗ өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн бусад байгууллага, хувийн хэвшил, олон улсын байгууллагатай хамтарч ажиллах.

5.2. ХАЗ-ийн дарга дараах эрхтэй:

5.2.1 ХАЗ-ийн эрх бүхий ялангуяа тушаалтны бүрэн эрхийг элчэх;

5.2.2.ХАЗ-ийн хурлыг даргалах, хурлын товыг тогтоож зарлан хуралдуулах, өөрөө оролцох боломжгүй бол төлөөний хүнийг томилох;

5.2.3.ХАЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

5.2.4.ХАЗ-ийн хурлын зөвлөмжийн хэрэгжилтийг ХАЗ-ийн гишүүдээс гаргуулж авах;

5.2.5.ХАЗ-ийг төлөөлж ХАЗ-ийн хурлаар хэлэлцсэн асуудлаар холбогдох байгууллагын удирдлагатай ярилцах, санал солилцох;

5.3. ХАЗ-ийн дарга дараах үүрэгтэй:

5.3.1.ХАЗ-ийн хурлын зохион байгуулалтыг удирдлагаар хангах;

5.3.2.ХАЗ-ийн хурлын шийдвэрийн гүйцэтгэлд хяналт тавих, гүйцэтгэлийг хуралд тайлагнах;

5.3.3.ХАЗ-ийн оролцогч байгууллагуудын хамтын ажиллагааг чиглүүлэх;

5.4.ХАЗ-д оролцогч байгууллагын эрх бүхий албан тушаалтан дараах эрхтэй:

5.4.1.ХАЗ-ийн хуралд асуудал оруулж хэлэлцүүлэх;

5.4.2.ХАЗ-ийн чиг үүрэгт хамаарах тодорхой асуудлыг хариуцан ажиллаж, гүйцэтгэл, үр дүнгийн талаар хуралд мэдээлэх;

5.4.3.ХАЗ-ийн шийдвэрийн дагуу оролцогч байгууллагын үйл ажиллагаатай танилцах;

5.4.4.ХАЗ-ийн даргын зөвшөөрснөөр ХАЗ-ийн шийдвэрт хяналт тавьж үр дүнг ХАЗ-ийн хуралд мэдээлэх;

5.4.5.ХАЗ-ийн чиг үүрэгт холбогдох асуудлаар оролцогч байгууллагаас баримт гаргуулан авах.

5.5.ХАЗ-ийн гишүүн байгууллагын эрх бүхий албан тушаалтан дараах үүрэгтэй:

5.5.1.ХАЗ-ийн хуралтай холбоотой бичиг баримтын нууцлалыг хангаж ажиллах;

5.5.2.Гишүүн байгууллагад хамаарах нууцыг чандлан хадгалах;

5.5.3.Гишүүн байгууллага тус бүрийн чиглэлээр хийгдэх энэ журмын 3.2-т заасан эрсдэлийн үнэлгээний зохион байгуулалтын ажлыг хариуцаж, биелэлтийг ХАЗ-д тайлагнах;

5.5.4.ХАЗ-өөс гаргасан санал, зөвлөмжид гарын үсэг зурж баталгаажуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Зургаа. Бусад

6.1.ХАЗ-ийн гишүүд болон түүнийг орлож ирсэн албан тушаалтанд хурлын ирцийг харгалзан улирал тутам урамшуулал олгох бөгөөд түүний хэмжээг ХАЗ-ийн даргын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч тогтооно.

6.2.ХАЗ-ийн дэргэдэх Ажлын хэсгийн гишүүдэд хуралд оролцсон байдал, хурлын ирц, идэвх санаачилгыг, харгалзан улирал тутам урамшуулал олгох бөгөөд түүний хэмжээг ХАЗ-ийн даргын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч тогтооно.

6.3.ХАЗ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын төсвийг тухайн жилийн эхэнд ХАЗ-ын даргын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч батална.

6.4.ХАЗ-ийн оролцогч байгууллагын бүтэц өөрчлөгдөх эсхүл тухайн байгууллагыг төлөөлөх өөр албан тушаалтанг томилох санал ирүүлсэн нь ХАЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэх үндэслэл болно.